


“МОНГОЛ ҮНДЭСТЭН БҮРЭН ЭРХТ УЛС БОЛОХ ЗАМД (1911 -1946)”

**Монголын түүх, олон улсын харилцааны
судалгааны зохиол., 22 х.х. УБ., 2005 он**



Зохиогч: Түүхийн шинжлэх ухааны доктор О.Батсайхан

Шүүн нягталсан: Профессор З.Лонжид

XX зууны турш үндэстнийхээ тусгаар тогтнол, бие даасан байдлын төлөө монголчуудын явуулж ирсэн үйл ажиллагаа бол Монгол “nation state” болохын төлөө тэмцэл байв. Эдүгээгийн Монгол улс нь Чин улсын хүрээлээс гарч чадсан цорын ганц үндэстэн болсоныг нотлох илэрхийлэл юм. Үүнд монголчуудын өөрсдийн санал санаачилга, хүч оролцоо ихээхэн боловч хойд хөрш Орос улсаас Алс Дорнодахин, түүний дотор Монголын талаар алсын хараатай бодлого явуулсаны үр дүн

болохыг архивын шинэ эх сурвалж, түүхэн баримтанд тулгуурлан тусгахыг хичээв. Монголын эх түүх хийгээд Дорнодахины түүх судлал сонирхогч хэн бүхэнд өгөөжтэй байх болов уу хэмээн найдмой.

Энэхүү номонд Монгол Улсын эзэн хаан Богд Жавзандамба хутагтаас Япон улсын Цог Жавхлант Эрхэмсэг эзэн хаанд илгээсэн захидал хийгээд Японы архивт буй Монголын түүхэнд холбогдох сурвалж, Зөвлөлт Холбоот Улсын тэргүүн И.Сталин лугаа Монголын төрийн тэргүүн, Ерөнхий сайд нарын хийсэн 21 удаагийн уулзалтын дэлгэрэнгүй протокол, Монголын тусгаар тогтнолын асуудлаарх АНУ, ЗХУ, Английн төрийн тэргүүн нарын уулзалтын заалт, ЗХУын тэргүүн И.Сталин болон Бүгд Найрамдам Хятад Улсын Ерөнхий сайд Сун Зэвэн нарын хэлэлцээрийн протоколууд зэрэг архивын шинэ сурвалжуудыг түлхүү ашиглахыг хичээсэн болно. Эл номноос

- Монголын тусгаар тогтнолын үнэ цэнэ юу вэ,
- Монгол - үндэстэн улс мөн үү,
- Манжийн хүрээлээс гарч чадсан орон Монголоос өөр байдаг юм уу,
- XX зууны Монгол улс бол Орос Японы нууц гэрээний үр дүн мөн үү,
- Монголын статус квог санаачлагч нь И.Сталин мөн үү зэрэг асуудалд хариулт олох болно.